

**ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 11 дүгээр сарын 08

№02

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн (1-203) өрөөнд 14:00 цагаас 95,7 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

**Хуралд:** Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Аюурзана, Б.Оюунтунгалаг, Л.Амартүвшин, Г.Өлзийсайхан, Б.Мөнхцэнгэл, Я.Батцэцэг, Ш.Цоож, П.Ууганбаяр, Р.Мядагмаа, М.Дэлгэрмаа, Ц.Энхтуул, Г.Батцэцэг, Д.Ариунболор, Ч.Улам-Оргил, Д.Цэрэндолгор, Д.Дулмаа, Д.Батдорж, ГУУС-ийн профессор Д.Гэрэлт-Од нар оролцов.

ГХС-ийн сургалтын чанарын албаны дарга А.Болормаа, БАТС-ийн бизнесийн удирдлага, менежментийн профессор Д.Биндиряа, ГУУС-ийн геологи, гидрогеологийн салбарын профессор Б.Мөнхцэнгэл нар гадаад томилолт, чөлөө авсан.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. Бүрэлдэхүүн сургуулиас хөтөлбөрийн талаар ирүүлсэн саналууд

Хөтөлбөрийн хорооны дарга Н.Эрдэнэхүү

2. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн хэлэлцүүлгээс гаргасан санал зөвлөмж

Хөтөлбөрийн хорооны нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа

3. Бусад асуудал

## **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. “ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн хэлэлцүүлгээс гаргасан санал зөвлөмж”-ийг танилцуулан цаашид БШУ-аас шинэчилсэн нийтлэг шаардлага батлагдахаар цөм хөтөлбөрийн шаардлагад тодорхой өөрчлөлт оруулах, Улаанбаатарын болон орон нутгийн сургуулиуд хөтөлбөр дамжуулан болон 2 сургуульд үндсэн хэлбэрээр хэрэгжүүлж буй салбар, тэнхим хүрээнд хамтын ажиллагаатай, санаачлагатай ажиллах, хөтөлбөрт боловсруулалтын үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах.
2. СХБА “Бүрэлдэхүүн сургуулиас хөтөлбөрийн талаар ирүүлсэн санал”-д хөтөлбөрийн ерөнхий хорооноос гарсан шийдвэрийг тусган БШУЯ-д хүсэлт гаргах.